



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/216/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13-14
4. Аудитын тайлан.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20-21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ОРХОНТУУЛ СУМЫН НЭГДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
З.ЭНХЦОЛМОН ТАНАА

2025.02.25 № СЭА-2025/26/НА-СТА-ТШЗ

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь заалтууд болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын чанар хүртээмж, сургалтын орчныг сайжруулах” чиглэлээр 2023 онд байгуулсан “Ирээдүйд хөтөлсөн өргөө холбоо” НҮТББ-ын арилжааны банкн дахь харилцах дансаар 2024 онд сумын баяр наадмын үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгжээс өгсөн **50,058.0** мянган төгрөгийн

хандив болон сумын ОНХС-аас хэрэгжүүлсэн цэцэрлэгийн тоглоом бэлтгэх **20,000.0** мянган төгрөгийн, Рашаант тосгоны цагдаад мотоцикл бэлтгэн нийлүүлэх **4,000.0** мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг тус тус хүлээн авч, зарцуулсан,

- Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 4 ажилтанд **654.6** мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон,
- Нийт **3,525.0** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шууд худалдан авах босго үнээс давсан цэцэрлэгийн хүүхдийн хоолны материалын худалдан авах ажиллагааг нийтэд ил тод зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус цэцэрлэг нь Боловсролын газраас 17,600.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом, стем тоглоомын тавиур, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 20,000.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом, хэрэглэгдэхүүн үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 5 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 92.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	129,237,753.07	195,030,738.98
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	74,055,699.64	103,929,879.61
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	74,055,699.64	103,929,879.61
3121	Төгрөг	74,055,699.64	103,929,879.61
31211	Төрийн сангийн харилцах	74,055,699.64	103,929,879.61
33	АВЛАГА	358,112.93	358,112.93
335	Бусад авлага	358,112.93	358,112.93
3351	Байгууллагаас авах авлага	358,112.93	358,112.93
35	БАРАА МАТЕРИАЛ	54,823,940.50	90,742,746.44
354	Хангамжийн материал	54,823,940.50	90,742,746.44
3542	Аж ахуйн материал	16,479,758.50	50,125,858.44
3546	Хүнсний материал	1,784,082.00	1,898,988.00
3547	Бусад хангамжийн материал	36,560,100.00	38,717,900.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	325,513,314.41	304,658,327.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	325,513,314.41	304,658,327.19
392	Биет хөрөнгө	311,665,314.29	291,060,327.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	334,037,899.00	334,037,899.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(46,949,710.40)	(60,149,186.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,168,400.00	22,168,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,586,681.89)	(16,768,995.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,638,663.88	17,638,663.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,656,400.10)	(14,339,991.80)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,062,733.40	12,062,733.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,048,889.60)	(5,588,496.24)
39217	Ном	1,999,300.00	1,999,300.00
393	Биет бус хөрөнгө	13,848,000.12	13,598,000.16
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(749,999.88)	(999,999.84)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,348,000.00	13,348,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	454,751,067.48	499,689,066.17
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	454,751,067.48	499,689,066.17
51	Засгийн газрын хувь оролцоо	454,751,067.48	499,689,066.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	90,475,639.00	90,475,639.00
51101	Өмч: - төрийн	77,127,639.00	77,127,639.00
512	Хуримтлагдсан үр дүн	157,760,889.13	202,698,887.82
5121	Өмнөх үеийн үр дүн	157,760,889.13	157,760,889.13
5122	Тайлант үеийн үр дүн		44,937,998.69
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	206,514,539.35	206,514,539.35
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	454,751,067.48	499,689,066.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	689,520,846.50	734,872,352.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,587,900.00	37,599,999.94
120	Нийтлэг татварын бус орлого	45,587,900.00	37,599,999.94
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	14,770,000.00	
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	30,817,900.00	37,599,999.94
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	643,932,946.50	697,272,352.17
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	608,150,834.00	664,427,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		664,427,500.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	106,049,034.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	502,101,800.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,782,112.50	32,844,852.17
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,782,112.50	32,844,852.17
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	499,769,338.87	689,934,353.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	499,769,338.87	689,934,353.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	497,125,738.87	689,934,353.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	352,304,404.00	511,105,367.02
210101	Үндсэн цалин	250,628,177.00	325,736,702.02
210102	Нэмэгдэл	85,559,658.00	177,425,926.00
210104	Урамшуулал	16,116,569.00	7,942,739.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,036,108.72	63,954,638.01
210201	Тэтгэврийн даатгал	30,071,177.30	44,097,575.97
210202	Тэтгэмжийн даатгал	3,494,335.66	5,013,168.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,795,539.55	2,506,634.54
210204	Ажилгүйдлийн даатгал	686,166.12	2,436,013.78
210205	Эрүүл мэндийн даатгал	6,988,890.09	9,901,245.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,315,112.50	31,844,852.17
210301	Гэрэл, цахилгаан	5,267,678.50	3,825,356.17
210302	Түлш, халаалт	26,535,434.00	26,410,496.00
210303	Цэвэр, бохир ус	1,512,000.00	1,609,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		4,175,200.00
210408	Бараа материал акталсны зардал		4,175,200.00
2105	Нормативт зардал	38,460,171.00	39,976,109.00
210502	Хоол, хүнс	38,460,171.00	39,976,109.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,467,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	2,467,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	785,100.00	539,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	785,100.00	539,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,757,842.65	37,338,587.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,251,019.00	11,383,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,420,200.00	5,100,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,086,623.65	20,854,987.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,643,600.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,643,600.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,643,600.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	189,751,507.63	44,937,998.69
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	224,660.40	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	224,660.40	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(224,660.40)	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	189,526,847.23	44,937,998.69

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	537,883,912.50	697,272,352.17
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	537,883,912.50	697,272,352.17
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	502,101,800.00	664,427,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		664,427,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	502,101,800.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,782,112.50	32,844,852.17
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,782,112.50	32,844,852.17
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	488,733,961.22	667,398,172.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	488,733,961.22	667,398,172.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	485,753,661.22	667,398,172.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	352,304,404.00	511,105,367.02
210101	Үндсэн цалин	250,721,010.00	325,736,702.02
210102	Нэмэгдэл	85,559,658.00	177,425,926.00
210104	Урамшуулал	16,023,736.00	7,942,739.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,036,108.72	63,954,638.01
210201	Тэтгэврийн даатгал	30,071,177.30	44,097,575.97
210202	Тэтгэмжийн даатгал	3,494,335.66	5,013,168.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,795,539.55	2,506,634.54
210204	Ажилгүйдлийн даатгал	686,166.12	2,436,013.78
210205	Эрүүл мэндийн даатгал	6,988,890.09	9,901,245.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,315,112.50	31,844,852.17
210301	Гэрэл, цахилгаан	5,267,678.50	3,825,356.17
210302	Түлш, халаалт	26,535,434.00	26,410,496.00
210303	Цэвэр, бохир ус	1,512,000.00	1,609,000.00
2105	Нормативт зардал	38,123,717.00	40,091,015.00
210502	Хоол, хүнс	38,123,717.00	40,091,015.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,467,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	2,467,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	785,100.00	539,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	785,100.00	539,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,722,219.00	18,862,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,302,019.00	13,562,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,420,200.00	5,300,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,980,300.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,980,300.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,980,300.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	49,149,951.28	29,874,179.97
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	49,149,951.28	29,874,179.97
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		74,055,699.64
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		103,929,879.61

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	90,475,639.00	206,514,539.35	(31,765,958.10)	265,224,220.25
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			189,526,847.23	189,526,847.23
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	90,475,639.00	206,514,539.35	157,760,889.13	454,751,067.48
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
12	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
15	Тайлант үеийн үр дүн			44,937,998.69	44,937,998.69
16	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	90,475,639.00	206,514,539.35	202,698,887.82	499,689,066.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	778,281,800.00	667,398,172.20	110,883,627.80	90.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	778,281,800.00	667,398,172.20	110,883,627.80	90.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	778,281,800.00	667,398,172.20	110,883,627.80	90.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	595,104,300.00	511,105,367.02	83,998,932.98	85.9
210101	Үндсэн цалин	389,524,800.00	325,736,702.02	63,788,097.98	83.6
210102	Нэмэгдэл	194,989,700.00	177,425,926.00	17,563,774.00	91.0
210104	Урамшуулал	10,589,800.00	7,942,739.00	2,647,061.00	75.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,841,300.00	63,954,638.01	6,886,661.99	90.3
210201	Тэтгэврийн даатгал	48,172,900.00	44,097,575.97	4,075,324.03	91.5
210202	Тэтгэмжийн даатгал	5,666,400.00	5,013,168.62	653,231.38	88.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,833,700.00	2,506,634.54	327,065.46	88.5
210204	Ажилгүйдлийн даатгал	2,833,700.00	2,436,013.78	397,686.22	86.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,334,600.00	9,901,245.10	1,433,354.90	87.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,526,400.00	31,844,852.17	8,681,547.83	100.0
210301	Гэрэл, цахилгаан	6,771,300.00	3,825,356.17	2,945,943.83	100.0
210302	Түлш, халаалт	31,658,500.00	26,410,496.00	5,248,004.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,096,600.00	1,609,000.00	487,600.00	100.0
2105	Нормативт зардал	42,474,200.00	40,091,015.00	2,383,185.00	94.4
210502	Хоол, хүнс	42,474,200.00	40,091,015.00	2,383,185.00	94.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	1,000,000.00	2,470,000.00	100.0
210604	Урсгал засвар	3,470,000.00	1,000,000.00	2,470,000.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,710,600.00	539,600.00	1,171,000.00	31.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,710,600.00	539,600.00	1,171,000.00	31.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,155,000.00	18,862,700.00	5,292,300.00	78.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,827,300.00	13,562,700.00	5,264,600.00	72.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,327,700.00	5,300,000.00	27,700.00	99.5
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	778,281,800.00	767,130,252.17	11,151,547.83	100.0
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	734,285,400.00	734,285,400.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	734,285,400.00	734,285,400.00	-	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,996,400.00	32,844,852.17	11,151,547.83	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	43,996,400.00	32,844,852.17	11,151,547.83	100.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		74,055,699.64	(74,055,699.64)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		103,929,879.61	(103,929,879.61)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилан цэцэрлэгийн менежментийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх, үнэлгээний тогтвортой хөгжлийг хангах, СӨБ-ын чанарт ахиц гаргахад үр дүнг ашиглах,
- Хувилбарт сургалт зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж хэрэглэгдэхүүний хөрөнгө оруулалт хийх,
- Цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эрх хамгааллын үйлчилгээ багш ажилтны ёс зүй хууль эрх зүйн мэдлэг чадварыг сайжруулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэгийн Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,938.0 мянган төгрөгөөр буюу 10.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	74,055.7	103,929.9	29,874.2
Авлага	358.1	358.1	-
Бараа материал	54,823.9	90,742.7	35,918.8
Үндсэн хөрөнгө	325,513.3	304,658.3	(20,855.0)
Нийт хөрөнгө	454,751.0	499,689.0	44,938.0
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	454,751.0	499,689.0	44,938.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	454,751.0	499,689.0	44,938.0

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 103,929.9 мянган төгрөг болж 29,874.2 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
2. Бараа материалын дансны үлдэгдэл 90,742.7 мянган төгрөг болж 35,918.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 53,802.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Боловсролын газраас 17,600.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом, стем тоглоомын тавиур, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 20,000.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 55,483.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 304,658.3 мянган төгрөг болж 20,855.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 518,957.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 43,996.4 мянган төгрөг нийт 562,954.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 215,327.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 734,285.4 мянган төгрөгөөр, нийт 778,281.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант 2024 онд 7 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 734,285.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 43,996.4 мянган төгрөгийн санхүүжилт, урьд оны үлдэгдлээс 74,055.7 мянган төгрөг зарцуулахаар зэрэг төсвийг нийт **778,281.8** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, НДШ-ийн зардлыг 208,563.3 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 1,710.6 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 6,908.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Хоолны зардлыг 1,953.1 мянган төгрөгөөр бууруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт **778,281.8** мянган төгрөгийн орлого

бүрдүүлснээс, урсгал үйл ажиллагаанд 667,398.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 667,398.2 мянган төгрөг буюу 85.8 хувьтай байгаа нь хоолны зардлыг 2,383.2 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 11,151.5 мянган төгрөгөөр, бусад зардлыг 7,968.4 мянган төгрөгөөр, боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 93,578.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
Улсын төсвөөс санхүүжих	734,285.4	634,553.3	103,929.9	86.4
80233-Хүүхэд хамгаалал	726.00	-	726.0	-
81605 - Эрүүл мэндийг дэмжих	1,874.90	1,430.00	444.9	76.3
81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	41,711.9	39,328.7	2,383.2	94.3
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,355.8	2,350.0	5.8	99.8
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	2,104.9	350.0	1,754.9	16.6
81832- Нүүдлийн бүлэгт хамруулах	17,309.3	12,272.6	5,036.8	70.9
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	661,162.6	571,782.0	93,578.3	86.5
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	7,040.0	7,040.0	-	100.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,996.4	32,844.9	11,151.5	74.7
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	43,996.4	32,844.9	11,151.5	74.7
ДҮН	778,281.8	667,398.2	115,081.4	85.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2024 оны анх батлагдсан төсвөөр/ хүүхдийн хоолны 42,907.7 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Буянт өргөн туул” ХХК,

О.Пүрэв, Б.Даваасамбуу, Сүхбаяр, Болорчимэг зэрэг иргэдтэй шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн хөрөнгийг орлогоор бүртгэж зарцуулалтад хяналт тавих зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 499,769.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,496.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Орхонтуул сумын нэгдүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,

- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллийг байршуулахаас 169 мэдээлэл байршуулан тухай бүр мэдээлэх 2 мэдээллийг хугацаа хоцроож 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

Хугацаа хоцроосон :

- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан – 1 удаа
- Дараа жилийн төсвийн төсөл – 1 удаа

Огт мэдээлээгүй:

- Худалдан авах ажиллагааны тайлан – 1 удаа

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Буянт өргөн туул” ХХК, О.Пүрэв, Б.Даваасамбуу, Сүхбаяр, Болорчимэг зэрэг

иргэдтэй шууд гэрээ байгуулж хүүхдийн хоолны материалын худалдан авалтыг гүйцэтгэсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 24/51 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 990.0 мянган төгрөгийн төсөвт тусгагдаагүй зардал гаргаж ур чадварын цалин хөлсийг илүү олгосон зөрчилд 1 төлбөрийн акт, нягтлан бодогчийг зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулсан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроосон 3 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 2 зөрчлийг арилгаж, худалдан авах ажиллагаа болон шилэн данстай холбоотой 2 зөрчлийг давтан гаргаж 50.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	990.0	1	990.0	100.0
Албан шаардлага					
Зөвлөмж	3	-	1	-	33.3
Нийт дүн	4	990.0	2	990.0	50.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 5,095.4 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Үр дүнгийн тайланд 4,175.2 мянган төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хасагдуулахдаа бараа үйлчилгээний зардлын дансаар, 720.3 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлыг шатахууны зардлаар тус тус тайлагнан үр дүнг буруу илэрхийлсэн,
- Санхүүгийн байдлын тайланд өмнөх жилүүдэд номонд элэгдэл байгуулснаас үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 199.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт **80,544.1** мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрч, 78,238.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 2,305.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1.Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 4 ажилтанд **654.6** мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

2. Бараа, ажил үйлчилгээний зардлаас урсгал засварын зардалд 1,175.0 мянган төгрөг, нөхөн хангалтын зардлаас хичээл практикийн зардалд 2,350.0 мянган төгрөг зэрэг нийт **3,525.0** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасныг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын”-ыг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

3. 2023 онд цэцэрлэгийн 60 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд эрхлэгчийн 2023 оны А/09 дүгээр тушаалаар “Ирээдүйд хөтөлсөн өргөө холбоо” НҮТББ-ыг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, удирдах зөвлөлийн даргаар жижүүр А.Мөнх-Эрдэнэ, гүйцэтгэх захирлаар бүлгийн багш Н.Оюунхишиг нарыг томилон хандив цуглуулж, захиран зарцуулах эрх олгосон байна. Ойн үйл ажиллагаа дууссан хэдий ч уг НҮТББ-ыг татан буулгаж, дансыг хаалгүйгээр 2024 онд сумын баяр наадмын үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгжээс өгсөн нийт **50,058.0** мянган төгрөгийн хандив / тус цэцэрлэгийн бус сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд хамаарах / болон сумын ОНХС-аас хэрэгжүүлсэн цэцэрлэгийн тоглоом бэлтгэх **20,000.0** мянган төгрөгийн, Рашаант тосгоны цагдаад мотоцикл бэлтгэн нийлүүлэх **4,000.0** мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг тус тус хүлээн авч, зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ” гэсэн заалт болон Сэлэнгэ аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсээс олгосон улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын чанар хүртээмж, сургалтын орчныг сайжруулах” гэсэн үйл ажиллагааны чиглэлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн бус байгууллагыг татан буулгаж, харилцах дансыг хаан үйл ажиллагааг зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 2,305.9 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Зардлын дансны ангилал буруу бүртгэсэн	2	4,895.5			2	4,895.5	2	4,895.5				
Номонд элэгдэл байгуулсан	1	199.9			1	199.9	1	199.9				
Дүн	3	5,095.4			3	5,095.4	3	5,095.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс цалин давхардуулан бодож олгосон	1	654.6			1	654.6						
Зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй	1	3,525.0			1	3,525.0						
Цэцэрлэгийн 60 жилийн ойтой холбоотой үүсэн байгуулагдсанТ ББ-ын дансаар ЭДТГ-ын хандивыг хүлээн авч зарцуулсан.	1	74,058.6			1	74,058.6						
Цэцэрлэгийн хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн, ариун цэврийн хэрэгслийг хүлээн авч бүртгэл тайланд тусгах	1	2,305.9					1	2,305.9				
Дүн	4	80,544.1			3	78,238.2	1	2,305.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлбэл зохих 2 мэдээллийг хугацаа хоцроосон	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хүүхдийн хоолны худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Нийт дүн	2	-			2	-		